

БАТЛАВ  
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
 С.ЭНХБАЯР  
 2024 оны 3 дугаар сарын 15 өдөр

**НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ГАДНА ТАЛБАЙН БАРИЛГА, ШУГАМ СҮЛЖЭЭГ БУУЛГАЖ,  
 ЭМНЭЛГИЙН НӨӨЦ ЭХ ҮҮСВЭРИЙГ ЗӨӨВӨРЛӨН, ЗОРИУЛАЛТЫН БАРИЛГА БАРИН  
 БАЙРЛУУЛЖ, ХОЛБОХ АЖИЛ**

2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 3 дугаар тогтоол.
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ, Зориулалт, хүчин чадал	- Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, дүүргийн нэгдсэн эмнэлэг. - Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн гал тогооны барилга, дулааны узель, гадна инженерийн шугам сүлжээний буулгаж, эмнэлгийн нөөц эх үүсвэрийг зөөвөрлөн, зориулалтын барилга барин байрлуулж, холбох ажил.
3.	Одоогийн байдал	- Ашиглалтын хугацаа дуусаж хуучирч муудсан.
4.	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5.	Төслийн иж бүрдэл	- Батлагдсан төсвийн дагуу буулгалтын ажлыг гүйцэтгэсэн тухай акт. - Өмнөх болон дараах байдлын фото зураг. - Хог хаягдлыг буулгасан тухай баримт бичгүүд хавсаргах - /БХБ-ын сайдын 2020 оны 48 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах" журмын дагуу бүрдүүлэх/
6.	Төсөл боловсруулах байгууллага	- Барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулалтаар сонгох.
7.	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар.
8.	Ажил гүйцэтгэх үе шат	- Батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээгээр барилга буулгалт, гадна инженерийн шугам сүлжээг зөөж шилжүүлэх ажлыг гүйцэтгэх. - Буулгалтын ажил хийгдсэний дараах барилгын хогийг цэвэрлэж, зам талбайг нөхөн сэргээх.
9.	Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага	- Буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ ил далд ажлын актыг үйлдэж фото зургаар тухай бүр баталгаажуулж байх.. - Буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ бусад аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй, орц гарцыг чөлөөтэй байхаар тооцон хаалт, хашаа болон анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу байрлуулах шаардлагатай. - Гадна инженерийн шугам сүлжээг зөөж шилжүүлэхдээ холбогдох норм дүрэм мөрдөх. - Цахилгааны генераторыг зөөх, шилжүүлэн суурилуулах байрыг хөнгөн хийцлэлээр шийдвэрлэж шилжүүлэн суурилуулах. - Ойролцоо барилгуудын инженерийн шугам сүлжээнд гэмтэл учруулахгүй байх арга хэмжээ авах. - Мод, бут, сөөг, шонгийн мод, узелийн барилга, генератор зөөж шилжүүлэх, гадна шугам сүлжээг буулгах зэрэг ажлыг санал болгож буй үнийн тооцон төсөв ирүүлэх. - Гүйцэтгэгч байгууллага нь барилгыг буулгах ажлыг тус ажлын хүрээнд хамаарах "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг мөрдөж ажиллана. - Талбайн тохижилтыг эвдэж сүйтгэхгүй байх, эвдэж сүйтгэсэн тохиолдолд нөхөн сэргээх зардлыг гүйцэтгэгч байгууллага

		<p>хариуцна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм БД 20-101-12 болон холбогдох бусад хууль, дүрмийг баримтлан ажиллана "Барилга захиалагчийн дүрэм", "Дүүргийн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах, хяналт тавих журам"-н дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ.</li> </ul>
10.	Дагаж мөрдөх хууль тогтоомжууд	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Эрчим хүчний тухай хууль</li> <li>- Хог хаягдлын тухай хууль</li> <li>- Бусад хуулиуд</li> </ul> <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилга захиалагчийн дүрэм</li> <li>- Дуу чимээ тусгаарлалт /БНБД 23-05-10/</li> <li>- Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам /БНБД 52-01-10/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul> <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000</li> <li>- Бусад холбогдох стандартууд.</li> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхтгэл UCS стандартын холбогдох бусад баримт бичгийг мөрдөх.</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨНШАГАЙ



